




**“УУЛ УУРХАЙН АШИГТ МАЛТМАЛЫН
ХАЙГУУЛ, АШИГЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН
ХЭРЭГЖИЛТ” 2018-2021 он
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ**





УУЛ УУРХАЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛААР



Ашиглалтын
тусгай
зөвшөөрөлтэй
55



Хайгуулын тусгай
зөвшөөрөлтэй
84



Бичил уурхайн
тусгай
зөвшөөрөлтэй
1

ЭВДРЭЛД ОРСОН ГАЗРЫН ТАЛААР



Аймгийн хэмжээнд 9 сумын
50 нэгж талбарын **159.4** га
газарт хууль бус
олборлогчдын үйл
ажиллагааны улмаас

Уул уурхайн ашиглалтын
улмаас эвдэрсэн **6** сумын **18**
нэгж талбарт **288.9** га газар
байна.





БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН БАТАЛГАА ХӨРӨНГИЙН ТАЛААР



ҮҮНЭЭС



2018-2021 онд буцаан олговол зохих барьцаа хөрөнгөнөөс **64,140.0** мянган төгрөгийг олгоогүй байна.

Нөхөн сэргээлтийн мэдээ гаргаагүй, тайлан ирүүлээгүй **87** лиценз эзэмшигчийн **23,430.0** мянган төгрөгийн барьцаа хөрөнгө байна

Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлбэл зохих дүнгээс дараах байдлаар байршуулсан.



- **4,775.0** мянган төгрөгийг илүү
- **10,381.0** мянган төгрөгийг дутуу



АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙН ДАВХЦАЛЫН ТАЛААР



Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй **42** талбайн **14,948.1** га нь усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн хилд давхцалтай байна.



Цогт, Бугат, Бигэр, Есөнбулаг сумын орон нутгийн тусгай хамгаалалттай газарт **9** хайгуулын тусгай зөвшөөрөлтэй **33,269.5** га

Бичил уурхайн олборлолтын талаар

Алтай сумын бичил уурхай эзэмшигчдээр нөхөн сэргээлт хийсэн эсэх нь тодорхойгүй, нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээн аваагүй.



Алтай сум нь зарим бичил уурхай эзэмшигчтэй гэрээ байгуулаагүй, зөвшөөрөлгүй ашигт малтмал олборлуулсан.



ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙГ БИЙ БОЛГОН, БИЧИЛ
УУРХАЙГ ДЭМЖИЖ, ЭВДЭРСЭН ГАЗРЫН НӨХӨН
СЭРГЭЭЛТИЙГ ИРГЭДИЙН НӨХӨРЛӨЛИЙН
ОРОЛЦООТОЙГООР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХЭЭР БАЙНА.

ЗӨВЛӨМЖ

Сумдын Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч
нарт:



Лиценз эзэмшигчидтэй нийгмийн
хариуцлагын гэрээ байгуулж,
биелэлтийг дүгнэж ажиллах.

Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан
лиценз эзэмшигчийн байршуулсан
мөнгөн хөрөнгийг хууль эрх зүйд
нийцүүлэн шийдвэрлэх.



Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх арга
хэмжээг хууль эрх зүйн хүрээнд зохион
байгуулах.

Тусгай зөвшөөрөлтэй талбайн орон
нутгийн тусгай хамгаалалттай газар болон
усны сан бүхий газрын хамгаалалтын
бүсийн давхцалыг арилгах арга хэмжээ авах





АЛБАН ШААРДЛАГА

**Сумдын Засаг дарга, Байгаль орчны улсын
байцаагч нарт:**




Түгээмэл тархацтай ашигт малтмалын
зөвшөөрлийн төлбөрийг төлүүлж байх.

Зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт
малтмалын нөөц ашиглаж байгаа зөрчлийг арилгах
арга хэмжээг авч хуульд нийцүүлэн шийдвэрлэх.



Бичил уурхайн үйл ажиллагааг хууль
тогтоомжийн хүрээнд явуулж, нөхөн
сэргээлтийг бүрэн хийлгүүлэх.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд
хяналт тавьж, байгаль хамгаалах менежментийн
төлөвлөгөөг жил бүр батлан, нөхөн сэргээлтийн
барьцаа хөрөнгийг бүрэн байршуулж хэвших.



Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны
менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үүргээ
бүрэн биелүүлсэн бол байршуулсан мөнгийг
буцааж өгч байх.

Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу, аккрузль
сууриар хөтөлж, санхүүгийн баримт материал, төлбөрийн
баримт, дансны хуулга, байгаль хамгаалах сангийн
санхүүгийн тайланг хууль тогтоомжийн дагуу архивлах.



Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй тооцоо
нийлж өглөгийг барагдуулах, Зөвшөөрөлгүй
ашигт малтмал олборлолтыг таслан зогсоох.